



**УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**

ИЛТГЭЛ

Сэдэв:

**“ Хосолсон сургалтаар суралцагчдын бие даан суралцах
чадварыг хөгжүүлэх “**

**Илтгэл бичсэн: Д.Мөнхцэцэг
М.Чулуунцэцэг**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

2022 ОН

АГУУЛГА

1. ТҮЛХҮҮР ҮГ

2. ОРШИЛ

- 2.1. Үндэслэл
- 2.2. Зорилго
- 2.3. Зорилт
- 2.4. Судалгааны арга
- 2.5. Хамрах хүрээ

3. ҮНДСЭН ХЭСЭГ

- 3.1 Онол арга зүй
- 3.2 Судалгааны хэсэг
- 3.3 Дүгнэлт

4. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- 4.1. Ном зүй
- 4.2 Бусад материал

1. ТҮЛХҮҮР ҮГ

Хосолсон, Цахим, Танхим, Тонгоруу, Холимог, зайнаас болон бие даан суралцах чадвар

2. ОРШИЛ

2.1. Үндэслэл

XX зууны дунд үед уламжлалт сургалт буюу танхимын сургалт зонхилж байсан бол XXI зууны хөгжлийн чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүхий л шатны боловсролын үйлчилгээнд орчин үеийн мэдээлэл технологийн дэвшилд суурилсан цахим болон танхимын хосолсон хэлбэрийг нэвтрүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна. Сургалтын энэхүү хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэхэд оюутан суралцагчдын суралцах арга барил хандлага, мэдээллийн технологийг ашиглах чадвар, цахим хэрэгсэл эзэмших, бие даан суралцах чадварыг сайжруулах шаардлага гарч ирж байна.

2.2. Зорилго

Хосолсон сургалтаар оюутан суралцагчдын бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд оршино.

2.3. Зорилт

- ✦ Сэдэвтэй холбоотой онолын материал цуглуулж, уншиж судлах
- ✦ Судалгааны аргаа сонгох
- ✦ Асуулга боловсруулах
- ✦ Асуулгын дагуу судалгаа авах
- ✦ Судалгаанд дүн шинжилгээ хийх
- ✦ Үр дүнг тодорхойлох

2.4. Судалгааны арга

Энэхүү илтгэлийг бичихдээ ажиглалт, харьцуулах, анализ, асуулгын аргуудыг ашиглан бичсэн. ГСЭ аймгийн Политехник коллежид 2020-2021 оны хичээлийн жилд суралцаж байгаа 586 оюутнаас санамсаргүй түүврийн аргаар 6 бүлгийн 110 суралцагчаас, 2021-2022 оны хичээлийн жилд суралцаж байгаа 550 оюутнаас санамсаргүй түүврийн аргаар 4 бүлгийн 110 суралцагчаас 3 асуулт бүхий судалгаат Google Form судалгааны платформ ашиглан авсан. Мөн мэргэжлийн боловсролын 27, тус сургуулийн 11 нийт 38 багшаас 4 асуулга бүхий судалгаа авч нэгтгэн үр дүнгт графикаар илэрхийлсэн.

2.5 Хамрах хүрээ

Уул уурхайн жишиг сургууль Говьсүмбэр Политехник коллежийн техникч, 1 жил, 2,5 жилийн 110 оюутан суралцагсад, мэргэжлийн боловсролын салбарын 38 багш нар хамрагдсан.

3. ҮНДСЭН ХЭСЭГ

3.1. Онол арга зүй

Хүн төрөлхтөн хөгжлийн джигитал эрин үед шилжиж байгааг илэрхийлэх тод жишээ бол зарим улс орнуудын боловсролын салбарт амжилттай хэрэгжж байгаа цахим буюу зайн сургалтын технологийн юм. Тиймээс ч уламжлалт сургалтыг цахим сургалтаар бүрэн орлуулахын оронд энэ 2 хэлбэрийг хослуулах нь илүү үр дүнтэй гэж үзсэний үндсэн дээр холимог /blended/, холимог /hybrid/, тонгоруу /flipped/ гэсэн сургалтын хэлбэрүүд үүсч хөгжин зарим орны их дээд сургуулиуд хэрэгжүүлээд тодорхой хугацаа өнгөрч байна. 21-р зууны суралцагчдын хэрэгцээ сонирхол цахим сургалт руу нэгэнт чиглэснийг тод харуулж байгаа бөгөөд дан ганц цахим сургалтаас илүүтэйгээр хосолмог болон холимог сургалтыг илүүд үзэж байгаа нь тодорхой харагдаж байна. Тухайлбал судлаач:

Graham "Холимог сургалт нь хүн хоорондын шууд харилцаагаар тодорхойлогддог уламжлалт сургалтын орчинт текст бичвэр (ном сурах бичиг, гарын авлага гэх мэт) болон мэдээлэл, харилцаа холбооны технологийг (МХТ)

Энх

суурилан сурацагч хувь хүний бие даан сурацагч чадвартай хослуулсан сурагчдын нэг хэлбэр хэмээн тодорхойлсон байдаг”.

Нартан ба бусад эрдэмтэд **холмог сурагч** гэдэг нь танхимын сурагчдын үр ашгтай байдал, тухайн сурагчаар нийгэмшүүлэх боломж зэргийг онлайн сурагчдын технологийн дэвшилтэй хослуулсан сурагч хүмүүжүүлэх арга ухааны нэгдэл юм гэж тодорхойлсон.

Тонгоруу сурагч нь холимог сурагчдын нэг төрөл бөгөөд уламжлалт сурагчдын орчныг тонгоруулан, цахимаар хичээлийн агуулгыг судалж, ангид гэрийн даалгавраа хийж, харицан яриа өрнүүлдэг сурагчдын нэг хэлбэр юм. Тонгоруу сурагчдад оюутан сурагчдад хичээл эхлэхээс өмнө тухайн хичээлтэй холбоотой багшийн бэлтгэсэн лекц, видео, дасгал даалгаврыг бие даан судалж, хичээл эхлэхэд өгөгдсөн сэдвийн талаар тодорхой мэдлэгтэй болсон байдаг. Тонгоруу сурагч нь багш төвтэй сурагчаас сурагчдад төвтэй сурагч руу шилжиж буйг илтгэх сурагчдын хэлбэр бөгөөд хичээлийн лекц болон бусад холбогдох материалыг мэдээлэл технологийн тусламжтайгаар цахим платформ ашиглан сурагчдад дамжуулж, тухайн хичээлээр үзэж судалсан зүйлийг танхимд гүнзгийрүүлэн ярицаж, мэдлэгээ хуваалцдаг сурагчдын арга хэлбэр юм.

Хосолмог /hybrid/ хэлбэрийн талаар ихэнх судлаачдын үзэл баримтлал, дэвшүүлсэн саналыг тоймлон үзвэл уг сурагч нь уян хатан чанартай, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурагчдыг явуулах боломжтой бөгөөд сурагчдад бие даан ажиллах чадвар, мэдээлэл олох, мэдээлэлтэй ажиллах чадварыг хөгжүүлж, хариуцлагатай байхад сурагчуудад давуу талуудтай сурагч юм.

Энэ талаар судлаач **Seifert 2017** онд бичсэн судалгааны өгүүлэлдээ “Хосолмог сурагч нь тусгай зохион байгуулалт, удирдлагаар олон төрлийн технологийг ашиглан, хичээлийг онцгой хэлбэр дизайны, заавраар явуулдаг төлөвлөгөөт сурагч юм...” гэсэн бол судлаач **Ibrahim** “Хосолмог сурагчдын хэлбэрийг идэвхитэй сурагч, нөөцөд суурилсан сурагч, хамтарсан сурагч, асуудалд суурилсан сурагчдыг явуулахад тохиромжтой гэж үзсэн байна.

Хосолмол сургалтын ирээдүйг тодорхойлон, дараах хэд хэдэн давуу талыг дурьдсан. Үүнд хосолмол сургалтыг хэрэгжүүлэх гол давуу тал нь багш болон оюутны хэн хэнд нь цаг хугацаа, хичээлийн хуваарь, хичээл заах арга хэлбэр, хичээлийн материалын харицааны чадвар зэрэгт уян хатан байдалтай сонголтүүдийг нэрлэжээ. Уламжлалт эсвэл онлайн дагнасан сургалтын хувьд зөвхөн нэг л арга хэлбэрийг сонгон ашигладаг. Харин хосолмол сургалт нь энэхүү хоёр сургалтын хамгийн зөв арга хэлбэрийг нэгтгэн явуулах боломжийг олгодог учраас хамгийн үр дүнтэйд тооцогддог гэсэн байна. Профессор, ахлах зэрэгтэй, 9-26 жилийн туршлагатай дөрвөн багш **Midwestern** их сургуулийн инженерийн коллежийн тэнхимд хосолмол сургалтын талаар судалгаа хийж дараах үр дүнгт тооцсон.

Судалгааны үр дүнгээс харахад үг сургалт нь:

1) бэрхшээлтэй асуудал шийдвэрлэх цагийг илүү олгодог
2) уян хатан байдалтай

3) бие даасан сургалтыг дэмждэг

4) суралцагч хоорондын харилцааг сайжруулдаг

5) оюутнуудын чадавхийг нэмэгдүүлэх зэрэг томоохон давуу талуудыг олгодог болохыг тодорхойлсон.

Хосолсон сургалт - Hybrid Learning • Хосолсон сургалт нь тусгай зохион байгуулалт, удирдлагаар олон төрлийн технологийг ашиглан, хичээлийг онцгой хэлбэр дийлж, заавраар явуулдаг төлөвлөгөөт сургалт юм.

Холимог сургалт - Blended Learning • Холимог сургалтын онлайн материалыг нь танхимын хичээлийн цагийг орлуулан нөхөх биш ангид хэлэлцсэн хичээлийн агуулгыг нэмж, дэлгэрүүлэн судлахаад зориулагдсан байдаг хэмээн үзсэн байна. Холимог сургалт гэдэг нь танхимын сургалтын үр ашгтай байдал, тухайн сургалтаар нийгэмшүүлэх боломж зэргийг онлайн сургалтын технологийн дэвшилтэй хослуулсан сурган хүмүүжүүлэх арга ухааны нэгдэл юм.

Тонгоруу сургалт - Flipped Learning Хичээлийн цаг ба гэрийн даалгаврын уламжлалт харилцааг эргүүлсэн сургалт. Суралцагч дээрээсээ онлайн хичээл,


сүргэлтийн үйл ажиллагаанд багшийн удирдлага дор оролцоно.	Давуу тал	Нийгэмших амьд харицаа биет бодит хэрэглэгдэх үнэ хатагч хамтран сүрлэх оролцоо	Бие даан сүрлэх чадвар Мэдлэгээ гүнзгийрүүлэх чадвар Мэдлэгээ гүнзгийрүүлэх боломж хуваалцах боломж, чадвар Бүтээлч байдал Эдийн засгийн хэмнэлт	Цаг хугацаа, орон зайн үнэ хатан нөхцөл бие даан сүрлэх чадвар Бүтээлчээр сүрлэх боломж Мэдлэгээ хуваалцах чадвар Хариуцлагатай байдал эзлэх чадвар	Орон зай, цаг хугацааны чөлөөт бие даан сонголт бие даасан бүтээлч байдал Эдийн засгийн хэмнэлт Байгальд эзлэх чадвар сүрлэхүй
сүргэлтийн үйл ажиллагаанд багшийн удирдлага дор оролцоно.	хэрэгсдээр оролцоно.	заасан хугацаанд багтаж цахимаар хийж оролцоно.	Эдийн засгийн хэмнэлт	Бие даан сүрлэх чадвар Мэдлэгээ гүнзгийрүүлэх боломж хуваалцах боломж, чадвар Бүтээлч байдал Эдийн засгийн хэмнэлт	Орон зай, цаг хугацааны чөлөөт бие даан сонголт бие даасан бүтээлч байдал Эдийн засгийн хэмнэлт Байгальд эзлэх чадвар сүрлэхүй

Хосолсон сүргэлтийн загвар нь уламжлалт заах арга зүйн нэг хэлбэр болох амьд, нүүр тулсан харицааг хөнгөвчлөх зорилгоор цахим технологийг хослуулдаг ба эдгээр хослолууд нь хосолмол сүргэлтийг нэвтрүүлэхэд ихээхэн давуу талтай байна. Сонирхолтой, бодит дасгалуудыг бий болгох нь зөвхөн сүрлэх бичгээс жишээ авахаас гадна багш, ажилчдаас багагүй хүчин чармайлт шаардагдаж байсан.


Суралцагчдаас авах судалгааны асуулга

1. Багш нарын боловсруулсан цахим хичээл хэр ойлгомжтой байсан бэ ?
 - A. Маш сайн
 - B. Сайн
 - C. Дунд зэрэг
2. Цахимаар хичээл орсоноор таны хувьд хэр үр дүнтэй гэж үзэж байна вэ?
 - A. Маш их үр дүнтэй
 - B. Дунд зэрэг
 - C. Үр дүн муутай
3. Ямар хэлбэрээр хичээл сургалт орвол таньд үр дүнтэй гэж бодож байна вэ ?
 - A. Цахимаар
 - B. Танхимаар
 - C. Цахим танхим хосолсон аргаар


Суралцагчдаас авсан судалгааны асуулгыг графикаар харуулав



2. Цахимаар хичээл орсоноор таны хувьд хэр үр дүнтэй гэж үзэж байна вэ?



3. Ямар хэлбэрээр хичээл сургалт орвол танд үр дүнтэй гэж бодож байна вэ?



Багш нараас авах судалгааны асуулга

1. Та ковидын үеийн сургалтын чанарт үнэлгээ өгнө үү ?
 - A. Сайн
 - B. Дунд
 - C. Муу
2. Та суралцагчдын хоцрогдлыг арилгахад ямар ямар арга хэрэглэж байна вэ ?


.....

.....


.....
3. Таны бодлоор цаашид хичээл сургалтыг ямар хэлбэрээр явуулбал үр дүнтэй гэж бодож байна вэ ?
 - A. Цахим
 - B. Танхим
 - C. Цахим, танхим хосолсон аргаар
4. Таны бодлоор цахим, танхим хосолсон сургалтын харьцаа хэд байвал тохиромжтой вэ ?
 - A. 10:90
 - B. 20:80
 - C. 30:70
 - D. 40:60
 - E. Бусад

Багш нараас авсан судалгааны асуулгыг графикаар харуулав


1. Та ковидын үеийн сургалтын чанарт үнэлгээ өгнө үү.




2. Та суралцагчдын хоцрогдлыг арилгахад ямар ямар арга хэрэглэж байна вэ?



3. Таны бодлоор цаашид хичээл сургалтыг ямар хэлбэрээр явуулбал үр дүнтэй гэж бодож байна.



4. Таны бодлоор цахим, танхим хосолсон сургалтын харьцаа хэд байвал тохиромжтой вэ?



3.3. Дүгнэлт

1. Олон улсын түвшинд хийгдэж байгаа сургалт, судалгааны ажлуудын үр дүнгээс харахад орчин үеийн мэдээлэл технологийн дэвшил төдийгүй нийгэм, эдийн засгийн байдал бүх шатны боловсролын үйлчилгээг цаашид цахимаар эсвэл танхим болон цахим хосолсон буюу холимог /blended/, хосолмол /hybrid/, тонгоруу /flipped/ гэх зэрэг сургалтын аль нэг хэлбэрт хурдацтай шилжих нөхцөл болж байна.

2. Хосолсон сургалтын хэлбэрүүдийг хэрэгжүүлэхэд тэдгээрийн төсөөтэй болон ялгаатай талуудыг ойлгох, сургах зүйн талаас багшлах боловсон хүчнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн дизайн болон хэрэглэгдэхүүнийг боловсруулах гэх мэт олон талын бэлтгэл ажил шаардлагатай болох нь харагдаж байна.

3. Уг судалгааны ажлаар дан танхимын хөтөлбөрөөр суралцаж байгаад давагдашгүй нөхцөл байдлын улмаас цахим хэлбэрт шилжин суралцаж байгаа Говьсүмбэр Политехник коллежийн 110 оюутнуудаас багшийн боловсруулсан цахим хичээлийн ойлгомжтой байдал, цахим хичээлийн үр дүн, ямар хэлбэрээр хичээл сургалт орвол үр дүнтэй вэ гэсэн 3 асуулгаар судалгаа авч үр дүнг нэгтгэхэд 56 % нь хосолсон сургалтыг нэвтрүүлэх нь тохиромжтой гэж дүгнэж байна.

4. Мэргэжлийн боловсролын салбарын 38 багшаас авсан 4 асуулгаар судалгаа авч нэгтгэхэд танхим цахим хосолсон хэлбэрээр сургалтыг зохион багуулах нь 68% нь үр дүнтэй гэж үзсэн байна.

5. Дээрх судалгаануудаас харахад хичээл сургалтыг цахим танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулах нь сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэхэд үр дүнтэй гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

4. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ❖ Ж.Төгсөө , Т.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа нарын “ Танхим болон цахим хосолсон сургалтын онол аргазүй” илтгэл – 2020
- ❖ Боловсролын хүрээлэн А. Энхтогтох “ Хосолсон сургалтын арга зүй” лекц
- ❖ Боловсролын хүрээлэн А.Энхтогтох, С.Гэндэнжамц нарын “ Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх чиглэл ба зохион байгуулалт” лекц
- ❖ Google.mn
- ❖ Legal info.mn
- ❖ slideshare.net
- ❖ prezi.com
- ❖ IKON .mn
- ❖ mn.wikipedia.org
- ❖ www.galaa.mn
- ❖ Bagsh.itpd.mn
- ❖ Kok.mn